

ОРОН НУТГИЙН ИХ ДЭЭД СУРГУУЛИУДЫН ЦАХИМ СУРГАЛТЫН ХЭРЭГЖҮҮЛЭЛТИЙН БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Б.Болортуяа¹, Б.Хонгорзул¹, Ц.Болормаа¹, Э.Мөнхчимэг¹,
Т.Буяндэлгэр², Р.Минжирмаа², Т.Гантулга³, Б.Доржпүрэв³, У.Баттамир¹, Б.Хандаа¹
¹АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар АУС

²Ховд Их Сургууль

³Дорнод Их Сургууль

bolortuya.b@mnumns.edu.mn

Хураангуй

Цахим сургалт нь мэдээлэл харилцааны технологийн дэвшилд суурилсан сургалтын орчин үеийн дэвшилтэт хэлбэр юм. Цахим сургалт, сургалтын материал хэрэглэгдэхүүн боловсруулахад багшаас цаг хугацаа, хүч хөдөлмөр, техник технологи болон мэдээллийн технологийн өргөн мэдлэг шаарддаг байна. Цахим сургалтын үйл ажиллагаа нь сургалтын төлөвлөлт, цахим сургалтын арга зүй, сургалтын агуулгын хөгжүүлэлт болон хэрэгжүүлэлт, оюутантай эргэх холбоо үүсгэх, оюутныг үнэлэх гэсэн хэсгүүдээс бүрддэг байна. Цахим онол, дадлага семинарын хичээлийн явцад багш оюутнуудаас цахим хичээлтэй холбоотой асуулуудыг авч үр дүнд дүн шинжилгээ хийх замаар цахим хичээлийн агуулга, чанарыг тогтмол баяжуулах боломжтой юм. Энэхүү судалгаагаар бид цахим сургалтын хэрэгжүүлэлтийн байдлыг тодруулахыг зорьсон болно.

Үндэслэл

Дэлхийн улс орнуудын боловсролын тогтолцоо нь мэдээлэл технологийн өндөр хөгжилтэй уялдан цахим хэлбэрт өдрөөс өдөрт шилжсээр байна. Мэдээлэл технологийн хөгжил нь цахим сургалтын арга хэлбэр, заах арга зүйн шинэчилэлд гол түлхэц болж байгааг боловсрол судлаачид онцолж байна¹. Сургалтын үйл ажиллагааг цахим хэлбэрээр үр дүнтэй зохин байгуулахад багшаас сургалтын хэрэглэгдэхүүнийг чанартай бэлтгэж хүргэсэн байдал, цахим сургалтыг хөтлөн чиглүүлэх чадвар, техник технологи ашиглах чадвар, техникийн доголдолгүй үйл ажиллагааг хангах чадваруудыг шаарддаг байна². АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар Анагаах Ухааны Сургууль, Ховд Их Сургууль, Дорнод Их Сургуулиуд нь 2019-2020 оны хичээлийн жилийн хаврын улирлын сургалтын үйл ажиллагааг цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан цахим хэлбэрээр зохион байгуулсан байна. Цахим сургалтанд оролцож буй багш нараас сургалтыг сайжруулахтай холбоотой асуумж, үнэлгээг тогтмол хийх нь цахим хичээлийг үр өгөөжийн нэмэгдүүлэх чухал хөшүүрэг юм. Судалгаагаар бид цахим сургалтын хэрэгжүүлэлтийн байдлыг тодруулахыг зорьсон болно.

Судалгааны зорилго

Багш нарын цахим сургалтын хэрэгжүүлэлтийн байдалд дүн шинжилгээ хийж тулгарч буй бэрхшээлүүдийг тодорхойлох

Зорилт

1. Багш нарын цахим сургалтын хэрэгжүүлэлтийн байдалд дүн шинжилгээ хийх
2. Цахим сургалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад багш нарт тулгарч буй бэрхшээлийг тодорхойлох

Судалгааны арга зүй

АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар Анагаах Ухааны Сургууль, Ховд Их Сургууль, Ховд Их Сургууль, Дорнод Их Сургуулийн багш нараас нэг агшингийн загварын тоон ба чанарын судалгааны аргаар судалгааг явууллаа. Судалгаанд тус 3 сургуулийн нийт 96 багш хамрагдсан байна. Судалгааны асуумжийг бүтцийн хувьд авч үзвэл судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл 8, цахим сургалтын талаарх хаалттай 11, нээлттэй 3 асуумж нийт 22 асуулт бүхий асуумжаар судалгааг 2020 оны 8-р сарын 28-ээс 9-р сарын 26-ны өдрүүдэд GoogleForme ашиглан цахим хэлбэрээр зохион байгууллаа. Судалгааны өгөгдөл мэдээлэлд SPSS программ ашиглан дүн шинжилгээ хийж, Т тест, ANOVA, Хи квадрат тестийн аргуудыг ашиглан таамаглалуудыг шалгасан ба Р утга 0.05-аас бага байх үед таамаглал батлагдсан гэж үзсэн болно.

Судалгааны үр дүн


АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар Анагаах Ухааны Сургууль, Ховд Их Сургууль, Ховд Их Сургууль, Дорнод Их Сургуулиудын цахим судалгаанд оролцогчдыг боловсролын зэргээр нь авч үзвэл 5.2 хувь нь бакалавр, 79.2 хувь нь магистр, 15.6 хувь нь докторын зэрэгтэй багш нар байна. Албан тушаарлын хувьд цагийн багш 7, дадлагажигч багш 7, багш 49, ахлах багш 25, дэд профессор 2, профессор 6 багш байна.

Хүснэгт 1.

Судалгаанд оролцогсодын ерөнхий мэдээлэл


Үзүүлэлт	Тоо	Хувь
1. Сургууль		
АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь АУС	23	23.8
Ховд Их Сургууль	41	42.6
Дорнод Их Сургууль	35	36.3
2. Ажилсан жил		
0-5 жил	12	12.5
6-10 жил	13	13.5
11-15 жил	27	28.1
16-20 жил	19	19.8
20-оос дээш жил	25	26.0
3. Насны байдал		
20-25 нас	4	4.2
26-30 нас	9	9.4
31-35 нас	20	20.8
36-40 нас	19	19.8
41-45 нас	24	25.0
46-50 нас	6	6.3
50-аас дээш нас	14	14.6

Бидний хамтарсан судалгаанд 12.5 хувь нь 0-5 жил ажиллаж байгаа, 28.1 хувь буюу 11-15 жил ажиллаж байгаа багш нар хамрагдсан байна.



Зураг 1. Цахим онол, дадлагын хичээл бэлтгэж буй байдал

Судалгаанд оролцсон багш нарын 51.0 хувь нь цахим дадлагын хичээл, 40.6 хувь нь онолын хичээл бэлтгэхдээ Power point програмыг ашигласан бол видео бичлэгийг онолын хичээлд 8.3 хувь, дадлагын хичээлд 5.2 хувь хэлбэрээр бэлтгэсэн байна.



Зураг 2. Цахим хичээл бэлтгэхэд зарцуулж буй хугацаа

Цахим онолын болон дадлагын нэг удаагийн хичээл бэлтгэхдээ багш нарын 40.6 хувь нь 3-4 цаг, 3.1 хувь нь 8-аас дээш цагийг зарцуулсан байна.

Хүснэгт 2.

Цахим сургалтын талаарх багш нарын өөрийн үнэлгээ

Асуумж	n, n%	Үнэлгээ					
		Маш хангалттай	Хангалттай	Дунд зэрэг	Хангалтгүй	Маш хангалтгүй	Дундаж үнэлэлт
Цахим хичээл бэлтгэх мэдээлэл технологийн мэдлэг, чадвар эзэмшсэн эсэх	Тоо	3	15	23	39	16	2.5
	Хувь	3.1	15.6	24	40.6	16.7	
Хичээлийн агуулгатай холбоотой сурах бичиг, нэмэлт материалуудыг хүргэсэн эсэх	Тоо	9	48	28	9	2	3.5
	Хувь	9.4	50	29.2	9.4	2.1	
Сургалтын явцад оюутнуудын суралцах идэвхийг өрнүүлэх, арга зүйн зөвлөгөөг өгсөн эсэх	Тоо	5	36	47	7	1	3.4
	Хувь	5.2	37.5	49	7.3	1	
Оюутнуудад даалгавар гүйцэтгэхэд арга зүйн зөвлөмжүүдийг хүргэсэн эсэх	Тоо	11	55	27	2	1	3.7
	Хувь	11.5	57.3	28.1	2.1	1	
Нийт дундаж							3.27

Цахим сургалтын үйл ажиллагааны талаарх багшийн сэтгэл ханамжийн үзүүлэлтээс харахад цахим хичээл бэлтгэх мэдээлэл технологийн мэдлэг, чадвар эзэмшсэн байдал нь 2.5 буюу хангалтгүй харин оюутнуудад даалгавар гүйцэтгэхэд арга зүйн зөвлөмжүүдийг хангалттай хүргэсэн буюу 3.7 гэж үнэлсэн байна.


Хүснэгт 3.

Багшийн сэтгэл ханамж түүний хамаарлын үр дүн

Үзүүлэлтүүд	Дундаж	Стандарт хазайлт	95% итгэх интервал утга		Р утга
			Доод утга	Дээд утга	
1.Цахим хичээл бэлтгэх мэдлэг чадварыг настай харьцуулсан байдал					
20-25 нас	2.000	.	.	.	0.14
26-30 нас	3.500	.7071	-2.853	9.853	
31-35 нас	4.333	.5774	2.899	5.768	
36-40 нас	2.500	.7071	-3.853	8.853	
41-45 нас	3.500	1.2910	1.446	5.554	
46-50 нас	4.000	.0000	4.000	4.000	
50 дээш нас	3.778	.6667	3.265	4.290	
2.Даалгавар өгөх арга зүйн зөвлөмж өгдөг байдлыг ажилсан жилтэй харьцуулсан дүн					
0-5 жил	3.000	.0000	3.000	3.000	0.23
6-10 жил	3.000	1.4142	.750	5.250	
11-15 жил	4.000	1.4142	-8.706	16.706	
16-20 жил	4.400	.8944	3.289	5.511	
20 дээш жил	3.400	.8433	2.797	4.003	
3. Цахим хичээлийн явцад суралцах идэвхийг өрнүүлэх, урамшуулан дэмжих, зөвлөгөө өгөх байдлыг ажилсан жилээс хамаарсан байдал					
0-5 жил	3.500	.7071	-2.853	9.853	0.27
6-10 жил	2.500	1.0000	.909	4.091	
11-15 жил	3.500	.7071	-2.853	9.853	
16-20 жил	3.800	1.3038	2.181	5.419	
20 дээш жил	3.100	.5676	2.694	3.506	

Хүснэгт 3-аас харахад багш нарын хичээлтэй холбоотой сурах бичиг, нэмэлт материалыг түгээсэн байдал нь тухайн хичээлийн онцлогоос хамааран тэнхимд ($p=0.01$) үзүүлэлтийн хувьд статистик ач холбогдол ажиглагдсан бол цахим

хичээл бэлтгэх, цахим сургалт зохион байгуулахад багшийн ажилласан жил, нас статистик хамааралгүй байна.



Зураг 3. Оюутныг дүгнэхэд багшийн зарцуулж буй цаг

Цахим сургалтанд хамрагдсан оюутны мэдлэг чадварыг үнэлэхэд 43.8 хувь буюу 42 багш 3-4 цаг зарцуулдаг бол 6.3 хувь нь 8 цагаас дээш хугацааг зарцуулдаг байна.

Хүснэгт 4.

Цахим сургалтын талаарх нээлттэй асуултын үр дүн

Үзүүлэлт	Тоо	Хувь
1.Цахим хичээлд бэлтгэхэд танд тулгарч буй бэрхшээл		
Техник технологийн чадвар дутмаг	27	28.1
Цаг хугацаа их шаардагддаг	20	20.8
Цахим орчны хүрэлцээ хангамж дутмаг	15	15.6
Оюутануудтай эргэх холбоо тогтооход бэрхшээлтэй	12	12.5
Бэрхшээл тулгараагүй боломжийн	12	12.5
Оюутныг үнэлэх бэрхшээлтэй байна	9	9.3
Олон хичээл заадаг тул ачаалал их байсан	6	6.3
Оюутны оролцоо муу	5	5.2
Хичээлд хэрэглэгдэх материал хомс	5	5.2
Багтаамж ихтэй видео бичлэг байршуулах боломжгүй	3	3.1
2.Цахим сургалтын явцад оюутнуудад тулгарч буй бэрхшээл		
Интернэт орчин дутмаг	28	29.1
Цахим хэрэгсэл хангамж дутмаг/компьютер, Ipad/	25	26
Цахим хэрэглэгдэхүүний ашиглах чадвар муу	24	25
Бие даан суралцах чадвар дутмаг	12	12.5
Сурах бичиг, сургалтын материал хүртээмж хангалтгүй	6	6.3
Хичээлээ сайн ойлгохгүй	6	6.3
Даалгавар их өгдөг	6	6.3
Эргэх холбоо муу	5	5.2
3.Цахим сургалтын давуу тал		
Цаг хугацаа хэмнэдэг	15	15.6
Хөгжүүлэх боломжтой сургалтын хэлбэр	9	9.3
Оюутны бие даан суралцах чадвар сайжирна	8	8.3
Багш оюутан хоёулаа техник, технологийн чадварт суралцана	8	8.3
Хичээлийг дахин сэргээн үзэх боломжтой	8	8.3
Цахим хичээл бэлтгэх мэдлэг чадвар сайжирсан	5	5.2
Эдийн засгийн ач холбогдолтой	2	2.1
Хэрэглэгдэхүүн бага зарцуулдаг	1	1.1

Хүснэгт 4-өөс харахад цахим сургалтыг зохион байгуулахад багш нарын 28.1 хувь нь техник технологийн чадвар дутмаг, 20.8 хувь нь хичээл бэлтгэхэд цаг хугацаа их шаарддаг, 15.6 хувь нь цахим орчны хэрэгцээ хүрэлцээгүй байна гэж хариулсан байна. Судалгаанд оролцсон багш

нарын 15.6 хувь нь цахим сургалт нь цаг хугацаа хэмнэсэн, 9.3 хувь нь хөгжүүлэх боломжтой сургалтын хэлбэр гэж давуу талуудыг дурьдсан байна.

Дүгнэлт

Цахим сургалтын хэрэгжилт нь 3.27 буюу дунд зэрэг байна. Цахим хичээл бэлтгэх мэдлэг, чадвар, оюутны суралцах идэвхийг өрнүүлэх, урамшуулан дэмжих, даалгавар өгөх арга зүйн зөвлөмж өгөх зэрэг нь ажилласан жил, насаар нь авч үзвэл статистик ач холбогдолгүй буюу хамааралгүй байна.

Цахим сургалт нь зайлшгүй хэрэглэгдэх, хөгжүүлж болох сургалтын хэлбэр мөн боловч багш нарт цахим сургалтын талаарх технологийн мэдлэг, чадвар дутмаг, цахим орчны хүртээмж хангалтгүй, хичээл бэлтгэхэд цаг хугацаа их шаарддаг, оюутантай эргэх холбоо тогтоох болон оюутныг үнэлэх боломж бага байдаг гэж үзэж байна.

Хэлцэмж

Өнөөгийн ниймгийн мэдээлэл технологийн хөгжлийг даган их дээд сургуулиуд нь сургалтыг идэвхитэй үр дүнтэй явуулахад цахим сургалтыг хөгжүүлэх шаардлагатай байна. Цахим сургалтын хэлбэр нь нээлттэй их сургууль болох хөгжлийг дэмжсэн сургалтын үйл ажиллагаа юм.

Судлаач Д.Сарантуяагийн “Зайн сургалтын хөгжлийн технологи” сэдэвт судалгаа, судлаач Л.Мөнхчулуун, Д.Хишигжаргал нарын “Цахим хичээлийн хэрэглээний судалгаа” сэдэвт судалгааны үр дүнгээс үзэхэд багш нарыг орчин үеийн мэдээлэл технологийн мэдлэг чадварыг өргөжүүлэн гүнзгийрүүлэх сургалтанд хамруулах, электрон техник ашигладаг багш нарын техник хэрэгсэлтэй ажиллах арга зүйг хөгжүүлэх, их сургуулийн цахим сургалтанд хэрэглэгдэх хамгийн сайн туршлагыг судлан турших гэж дүгнэсэн байна. Энэ нь бидний судалгааны цахим сургалтыг хэрэгжүүлэхэд багшид тулгарч буй бэрхшээл нь техник технологийн чадвар дутмаг, цахим орчны хангамж муу, цаг хугацаа их шаарддаг, оюутантай эргэх холбоо тогтоох болон оюутныг үнэлэх боломж бага гэж гарсан нь цахим сургалтын арга зүйг хөгжүүлэх сургалт шаардлагатай байгааг харуулж байна.

Ашигласан ном зүй

1. АШУУИС, СБЗГ, Анагаах ухааны боловсрол судлал, УБ, 2018
2. АШУУИС, Монголын анагаах ухааны боловсролын шинэчлэл, УБ, 2011
3. МАУБХ, Анагаах ухааны боловсрол, УБ, 2011
4. Сургалтын бодлого зохицуулалттай холбоотой дүрэм журмын эмхэтгэл (2019) АШУУИС, СБЗГ, УБ,
5. С.Батхуяг, Б.Төртогтох, Н.Цогзолмаа, (2019) Боловсрол судлалын судалгааны ажлын арга техник, УБ,